



**СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 1/90

Сант сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2, 18.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Ивэн багийн нутаг дэвсгэр, Хойд булагийн аманд ой нөхөн сэргээх гэрээнд тусгагдсан ажил, Орхон голын гүүрний Амарбаясгалант хүрэх замыг тэмдэгжүүлэх ажлыг тус тус хүлээн авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Мөнх-Эрдэнэ

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Л.Сэлэнгэсайхан

(Ивэн багийн Засаг дарга)

А.Батдорж

(Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)

Ч.Төгсбаатар

(Байгаль хамгаалагч)

Г.Ууганцэцэг

(Санхүү албаны дарга)

2.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (А.Одхүү)-д даалгасугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: *Л. Насибов*
Хянасан: *Л. Насибов*
Хувь: *1*